

ДАВХАР ГИЙГҮҮЛЭГЧ БА ЭРТНИЙ МОНГОЛ ХЭЛНИЙ
ҮЕИЙН БҮТЦЭД ХОЛБОГДОХ НЭГЭН ӨВӨРМӨЦ ХАНДЛАГА

М. Баярсайхан *

Монгол бичгийн хэлэнд үе жийрэглэх нь, түүний учир

Сонгодог монгол бичгийн хэлний зөв бичих зүйд жийрэг эгшгийн дүрэм (бас холбох эгшгийн дүрэм гэдэг) гэж бий. Тэрхүү дүрмээр гийгүүлэгчээр төгссөн үйл үндсэнд *ү, ү, г, н, т, л, р* гийгүүлэгчээр эхэлсэн бүтээвэр залгахад хооронд нь уруулын эгшиг тэмдэглэх гэдэс жийрэглэж бичдэг¹. Энэ нь эртний монгол хэлний авианы байрлалын хуулиар хоёр гийгүүлэгч авиаг салгах үүрэгтэй гарч ирсэн эгшгийг бичигт тогтолцоотой тусгасан хэрэг юм. Жишээлбэл, *γar-mui > γarumui*, *ol-mui > olumui*, *nis-mūi > nisūmūi*, *od-mui > odumui*, *qan-mui > qanumui* гэх мэт. Гэтэл *-γ/g, -b, -d* дэвсгэрээр төгссөн үгийн дараа мөн тэдгээр гийгүүлэгчээр эхэлсэн бүтээвэр залгахад *-γu/-gū-, -bu/-bū-, -du/-dū-* үе жийрэглэх нь нэгэнтээ тогтворжсон журам болно. Үүнд, дээрхийн адил дан эгшиг “*-u/-ū-*”-г жийрэглэхэд монгол хэлний авианы байрлалын хууль, авианы нийлц талаас гажих зүйлгүй атал, яагаад заавал үе жийрэглэсэн бэ хэмээх асуулт тулгарч байна.

Сургалт, судалгааны бүтээлүүдэд ийнхүү үе жийрэглэн бичих тогтсон заншил байдаг хэмээн дурддаг боловч, ихэнхдээ учрыг нь тайлбарлалгүй орхисоор ирлээ. Тайлбарласан цөөн судлаач үе жийрэглэх нь хожуу гарсан, дүрс ялган бичихтэй холбоотой бичлэг гэж үзсэн байна. Тухайлбал, эрдэмтэн Гаруди « “*ōg*” гэх үндсэнд олонхидоо *ū* эгшгээр завсардуулан зайчлуулдаг. Энэ үг Дундад эртний монгол хэлэнд хэлбэрийн авиа зохицлын талаар үндсэндээ бусад үгнүүдтэй адилавтор байснаа Дундад үеийн монгол хэлэнд бага зэрэг өөрчлөлт гарч эхэлж *-gū* үеэр зайчлуулан халхлах болжээ. Энэ нь гол төлөв дүрс бичлэгээрээ утга ялгах шаардлагаас шалтгаалсан байж болох »² гэжээ. Мөн Б.Я.Владимирцов³, Шонхор⁴ зэрэг эрдэмтэн “дүрс бичлэгээр утга

* МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг судлалын тэнхим

¹ Үүнээс гадна уг дүрэмд үл хамаарах *а, е, і* эгшиг жийрэглэсэн тохиолдол монгол бичигт цөөн бус буй.

² Garudi, Dumdadu erten-ū mongyol kele (Kōkeqota: Цбыг Mongyol-un Arad-un Keblel-ын Qoriy-a 2001) 264 дүгээр тал.

ялгах шаардлагаас шалтгаалсан” байж болох юм гэж үзсэн байна. Тухайлбал, “өгсөн”, “үхсэн” хоёр үгийг дүрс ялгахын тулд *öggügsen* (eoiKhsea), *ükügsen* (eoiKhsea) гэж бичдэг гэжээ.

-du/-dū-, -bu/-bū-, -γu/-gū- үе жийрэглэдэг үгсээс жишээлбэл:

<i>durad-mui</i>	>	<i>durad-dū-mui</i>	“дурдмуй”
<i>ebed-mūi</i>	>	<i>ebed-dū-mūi</i>	“өвдмүй”
<i>söğüd-mūi</i>	>	<i>söğüd-dū-mūi</i>	“сөгдмүй”
<i>jib-mūi</i>	>	<i>jib-bū-mūi</i>	“живмүй”
<i>kōb-mūi</i>	>	<i>kōb-bū-mūi</i>	“хөвмүй”
<i>čib-mūi</i>	>	<i>čib-bū-mūi</i>	“чивмүй”
<i>čōb-mūi</i>	>	<i>čōb-bū-mūi</i>	“цөвмүй”
<i>ög-mūi</i>	>	<i>ög-gū-mūi</i>	“өгмүй”
<i>geyeg-mūi</i>	>	<i>geyeg-gū-mūi</i>	“гээгмүй”
<i>kiruγ-mui</i>	>	<i>kiruγ-yu-mui</i>	“хярмуй”
<i>būg-mūi</i>	>	<i>būg-gū-mūi</i>	“бүгмүй”
<i>gōg-mūi</i>	>	<i>gōg-gū-mūi</i>	“гөгмүй”

гэх мэт олон жишээ тоочиж болно⁵. Өнөө ‘*abuba*’ (*авав*) гэж бичдэг үгийг хуучны бичгийн зүйлд *ab-bu-ba*⁶ хэмээн бичсэн тохиолддог ажээ. Эдгээр жишээ хийгээд энд эс дурдсан бусад хэдэн зуун ийм бичлэгтэй үгийг дүрс ялган бичихийн тулд үе жийрэглэжээ гэж тайлбарлах нь оновчгүй юм. Ажиглавал, энэ мэт бичлэгтэй үгс цаг хугацааны хувьд эрт үед хамаарах тусмаа улам тогтвортой ажгуу. Тухайлбал, *duraddumui*, *ebeddūmūi*, *söğüddūmūi* хэмээн -du/-dū- үе жийрэглэдэг, эсхүл *duradumui*, *ebedūmūi*, *söğüddūmūi* хэмээн -u/-ū- дан эгшиг жийрэглэдэг хоёр янз бичлэгийн эхнийх нь эрт үеийн дурсгалд тогтвортой тохиолдож байсан бол хойшлох тусам хоёрдох бичлэг олширсоор эдүгээ нэг мөр болон хэвшиж байгаа болно. Ийнхүү үе жийрэглэж буй нь эртний монгол хэлний онцлогоос үүдсэн, авианзүйн учир шалтгаан бүхий давхар гийгүүлэгчийг монгол бичгийн зөв бичих зүйд тусгасан хэрэг гэж бодож байна. Үүнчлэн *öggüyetür*, *čuyγar* зэрэг бичлэгтэй үгс бий.

Жийрэг эгшиг -u/-ū- бүхий үгсийн тухайд, хэдийгээр дан эгшиг жийрэглэж бичдэг боловч, чухам эрт цагийн амьд дуудлага нь бас л давхар гийгүүлэгч гарган хэлдэг байсан хэмээн баттай хэлж болно. Жишээлбээс:

Бичлэг нь:	<i>qan-mui</i> > <i>qanumui</i>	дуудлага нь:	/qannumui/
	<i>ol-mui</i> > <i>olumui</i>		/ollumui/
	<i>čin-mui</i> > <i>činnūmūi</i>		/činnūmūi/

³⁾ Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. М., 1929.

⁴⁾ Šongqor, Erten-ü mongyol kelen-ü sudulul. Kōkeqota, 1996.

⁵⁾ “г- /γ, g/” гийгүүлэгчээр төгссөн “өг-” хэмээх ганц л үйл үг байдаг гэх ба “б- /b/”-гээр төгссөн үйл үг нь “хөв-, жив-, ав-” гурав төдий хэмээн зарим монгол бичгийн сургалтад зааж, бичиж ирснийг цаашид залруулах хэрэгтэй юм.

⁶⁾ C.Norjin, Mongyol kelen-ü yool yosu. Kōkeqota, 1987, 351 дүгээр талд.

<i>nis-mūi</i> > <i>nissūmūi</i>	/nissūmūi/
<i>tun- mui</i> > <i>tunnumui</i>	/tunnumui/
<i>kūr-mūi</i> > <i>kūrrūmūi</i>	/kūrrūmūi/
<i>sun- mui</i> > <i>sunnumui</i>	/sunnumui/
<i>asay- mui</i> > <i>asayumui</i>	/asayumui/
<i>qulay-mui</i> > <i>qulayumui</i>	/qulayumui / мэт байсан гэлтэй.

Өөрөөр хэлбэл, гарч ирж буй давхар гийгүүлэгч нь өгүүлүүр болон сонсолзүйн талаас үл ажиглагдахуйц болтол тод бус хэлэгдэхийг дагалдан дан эгшиг жийрэглэж бичих болсон биз ээ. Сүүлчийн хоёр үгийн тухайд эртдээ –үи үе жийрэглэж байснаа хожим –и жийрэглэсэн бичлэгээр хэвшсэн байж болно.

Чингээд монгол бичгийн хэлэн дэх үе жийрэглэхийн учрыг олох гэсэн маань монгол хэлний давхар гийгүүлэгчийн тухай асуудлыг хөндөхөд өөрийн эрхгүй хүргэсэн буюу.

Монгол хэлний давхар гийгүүлэгч, түүний бичгийн дурсгал дахь баримт

Хэлшинжлэлийн бүтээлүүдээс лавлан үзвэл, гийгүүлэгч авиаг уртаар дуудах болон нэг үгийн бүрэлдэхүүнд нэг ижил авиаг дараалан өгүүлэхийг давхар гийгүүлэгч буюу геминат (geminate) хэмээн томъёолжээ. Монгол хэлтэй төрөлсөх Алтай овгийн залгамал хэлнүүдээс Япон хэлэнд давхар гийгүүлэгч түгээмэл байдаг. Нэг үе түрэгийн төрөл хэлнүүдэд давхар гийгүүлэгч байхгүй гэж үздэг байснаа сүүлийн үес түрэг хэлэн дэх давхар гийгүүлэгчийн талаар хэд хэдэн судалгааны бүтээл гарчээ. Солонгос, манж-түнгүсийн хэлэнд бас давхар гийгүүлэгч гэж болохоор баримт жишээ бий.

Монгол хэлний зарим аялгуунд гийгүүлэгчийг уртаар хэлдэг тухай Б.Я.Владимирцов⁷, М.Левицки⁸, А.М.Позднеев⁹, П.Пельо¹⁰, Ш.Лувсанвандан¹¹, Д.Төмөртоого¹², Ж.Санжаа, Ж.Надмид¹³, Ё.Сайто¹⁴ нарын олон эрдэмтэн дурдсанаас гадна, М.Левицки, Д.Төмөртоого¹⁵, Ё.Сайто¹⁶ зэрэг эрдэмтэн хятад (Монголын Нууц

⁷) Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика, М., 1989, 412 дугаар талд.

⁸) Marian Lewicki. LA LANGUE MONGOLE DES TRANSCRIPTIONS CHINOISES DU XIV SIECLE. Le Houa-yi yi-yu de, 1389, WROCLAW 1949. 120 p.

⁹) мөн тэнд

¹⁰) мөн тэнд

¹¹) Ш.Лувсанвандан, Орчин цагийн монгол хэл. Авиа авиалбар хоёр нь, Улаанбаатар, 1967. 54т.

¹²) Д.Төмөртоого, “Бүтээврийн харьцаанд гийгүүлэгч давхарлах ёс (Дундад үеийн монгол хэлний жишээн дээр), 2000,” // Монгол хэлшинжлэлийн онол, түүхийн асуудалууд, 549т. 149-153 дугаар талд.

¹³) Ж.Санжаа, Ж.Надмид, Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй, Улаанбаатар, 2008, 190, 229-230 дугаар талд.

¹⁴) Consonant Gemination in Mongolian, Consonant Gemination in Mongolian, Bulletin The IAMS News Information on Mongol Studies 1996 No.1(17), No.2 (18), 72-79 pp.

¹⁵) Д.Төмөртоого, Эртний монгол хэлний гарах тийн ялгалын дагаварын нэгэн хувилбар, Монголын судлал, VI:20, 1968, 50-52; Д.Төмөртоого, “Бүтээврийн харьцаанд гийгүүлэгч давхарлах ёс (Дундад үеийн монгол хэлний жишээн дээр), 2000,” // Монгол хэлшинжлэлийн

Товчоон, Хуа-и и-ю) болон араб (Мукаддимат ал-Адаб) үсгээрхи монгол хэлний дурсгалд бүтээврийн зааг дахь давхар гийгүүлэгчийг хэрхэн тэмдэглэсэн талаар ажиглалт хийж тусгайлсан өгүүлэл хүртэл нийтлүүлжээ. Эрдэмтдийн судалгаанаас харахад хятад болон араб үсгийн монгол хэлний дурсгалуудад “*mōren-nū, qaha:n-ni, usun-na, ōkin-ni, olan-naṣa, noqai-yaṣa, otaṣi-yasa, aiqū-wasa, jegūdūn-niyen*” гэх зэргээр харьяалах, орших, гарах, заахын тийн ялгал хийгээд хамаатуулахын нөхцөлийн өмнө тухайн үгийн үндсийн эцсийн гийгүүлэгчтэй ижил, эсвэл эцсийн эгшигтэй ойролцоо гийгүүлэгч болох -n-, -y-, -w- гарч ирсэн жишээ цөөн бус ажээ. Профессор Ё.Сайто монгол (уйгуржин), дөрвөлжин, хятад, араб, төвд, солонгос, манж, латин зэрэг үсэг бичгээрх монгол хэлний дурсгалуудад давхар гийгүүлэгчийг хэрхэн тэмдэглэсэн талаар илрүүлэн сурвалжилж, халх, буриад, ойрд аялгуунд гийгүүлэгчийг уртаар өгүүлдэг зарим жишээг харьцуулсан тун сонирхолтой судалгаа хийсэн байна.

Өмнөх эрдэмтдийн дурдсан жишээ баримт дээр өөрийн олж ажигласан зарим баримтыг нэмэрлэе.

Lao kida (1790), *Chop hae mong-o* (1790), *Mong-o yuhae* зэрэг солонгост гарсан монгол хэлний сурах бичиг, *Han-i araha manju mongyo niqan hergen ilan hačin-i mudan aṣaha buleku bidhe*, *Han-i araha manju mongyo gisun-i buleku bidhe* зэрэг манж толь бичгүүдэд -n дэвсгэртэй үгийн дараах харьяалахын тийн ялгалын нөхцөлийг -*ni*, -*nū*, -*nai*, -*nei*, -*ni* хэмээн бараг бүгд давхар гийгүүлэгчтэй дуудлага тэмдэглэсэн байна.

17-20 дугаар зууны эхэн үе хүртэлх уран зохиол, түүхийн сурвалж, албан бичгээс аваад элдэв зүйл монгол бичгийн үлэмжхэн дурсгалын дотор тухайн цагийнхаа аман дуудлагыг дагаж, зөв бичих зүйгээс ангид бичсэн тохиол түгээмэл байдаг бөгөөд үүний дотор мөнөөхөн давхар гийгүүлэгчийг тэмдэглэсэн баримт ч олон таарч байна. “Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс”-наа ийм баримт тун элбэг тохиолдож байгаагаас 12 дугаар ботид¹⁷ буй зарим сонирхолтой жишээг дурдвал:

“*ene oros-sai būdūgūn noyan geji ṣōkūdū bayising bariju...*”;

“*ṣay-giin alba ṣayani bariyulji...*”;

“*qangyai nutuy-γan orkin yadaju...*” гэжээ.

Oros-un/оросын/, ṣay-un/цагийн/, nutuy-γan /нутгаа/ хэмээх үгсийг давхар гийгүүлэгчтэй дуудаж байсныг энэ бичлэг харуулж байна.

Хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгал “Хутагт Жавзандамба ламын цадиг оршив” нэрт сударт¹⁸:

онол, түүхийн асуудалууд, 549т. 149-153 дугаар талд.

¹⁶⁾ Yoshio Saito, Geminate Consonants in Middle Mongolian. One Phenomenon in the Text of Chinese Transcriptions, Bulletin of the Japan Society for Mongolian Studies, No.20.[J] 1989; Consonant Gemination in Mongolian, Consonant Gemination in Mongolian, Bulletin The IAMS News Information on Mongol Studies 1996 No.1(17), No.2 (18), 72-79 pp, Chyuuki mongorugo no moji to onsei (Scripts and Sounds in Middle Mongolian), KYOTO SYOKADO 2003, 85-104 pp.

¹⁷⁾ Daičing ulus-un dotoyadu yamun-u mongyol bičig-ūn ger-ūn dangse, Kōkeqota, 2005, 12 дугаар боти.

¹⁸⁾ Р.Бямбаа, Занабазарын дөрвөлжин үсэг, Улаанбаатар, 2005, 70-73т.

Хэвтээ дөрвөлжин үсгээр бичсэн нь	Монгол бичгийн галигаар
<i>ti-gũ᠓-nũ</i> (4b.1.)	tegũn-ũ
<i>ti-kũ᠓-nũ</i> (5b.1.)	tegũn-ũ
<i>bi-lig-gi</i> (4b.6.)	bilig-i
<i>ka-mug-gi</i> (4b.6.)	qamuy-i
<i>tõ-bod-dũn</i> (3a.4.)	tũbed-ũn
<i>te-bed-dũ᠓</i> (6a.3)	tũbed-ũn
<i>tũ-bed-dũ᠓</i> (5b.4.)	tũbed-ũn
<i>o-mo-ta᠓-ni</i> (3a.4)	amitan-i
<i>a-mi-ta᠓-no</i> (5b.1.)	amitan-u
<i>ba-ri-mid-di</i> (5a.1.)	baramid-i
<i>su-dur no-god-di</i> (5a.1.)	sudur nuyud-i
<i>na-so᠓-no</i> (6a.1.)	nasun-u
<i>e-kũ᠓-nũ</i> (6a.5.)	eke-yin
<i>ag-sa᠓-no</i> (6a.5)	a᠑san-u
<i>jo᠓-no</i> (6b.1.)	jun-u
<i>er-dem-mũ᠓</i> (7a.1.)	erdem-ũn
<i>ked-di</i> (7a.2.)	keyid-i

Энд тийн ялгалын заагт -dd-, -mm-, -gg-, -᠓n- гэсэн давхар гийгүүлэгч гарчээ. Дашрамд, тэмдэглэхэд дурдсан судрыг тухайн бичээч хэвтээ дөрвөлжин үсгээр бичих цаг үед Төв Халхын аялгуунд үгийн эцэст орсон хэлний урдуурх ‘-n’ гийгүүлэгчийг хэлний хойгуурх -᠓-ээр нэгэнтээ хэлдэг болчихоод байсныг дээрх хэдэн үгийн галиг харуулж байна.

Соёмбо үсгээр ч мөн давхар -nn- гийгүүлэгчийг тэмдэглэсэн байдаг. “*Õ-be-sun tõ-rõg-san u-kān ne-re-tũ kan-nu tu-ji oro-si-gā*” (Өөсөөн төрсөн ухаан нэрт хааны тууж оршвой) хэмээх соёмбо үсгийн номын гарчигт “*kan-nu*” гэж бичжээ.

Давхар гийгүүлэгч гарч ирдэг үзэгдлийг эрдэмтэд авиа ижилсэх хандлагатай холбон үзэж байна. Миний бодлоор дундад үеийн монгол хэлний баримт дахь давхар гийгүүлэгч гарч ирж буй гол шалтгаан нь үеийг гийгүүлэгчээр зааглан хэлэх гэсэн эртний монгол хэлний нэгэн өвөрмөц хандлагатай холбоотой юм. Тэрхүү үе зааглан гарч ирж буй гийгүүлэгч нь авианы ижилсэлээр илэрч, давхар гийгүүлэгчийг бий болгожээ.

Монгол хэлний үе битүүлэн гийгүүлэгч нэмэгдэх үзэгдэл

Задгай үеийг битүүлэн гийгүүлэгч нэмэгдэх үзэгдэл бол эртний монгол хэлэнд тун идэвхтэй байгаад хойшлох тусам алдарсаар ирсэн, эдүгээ ул мөр нь байсаар байгаа монгол хэлний авианзүйн өвөрмөц үзэгдэл юм. Энэхүү хандлага нь их төлөв бүтээврийн зааг дээр гарч ирдэг бөгөөд

1. Үе бүтээж буй эгшгийн өмнө гийгүүлэгч нэмэгдэх,
2. Үе бүтээж буй эгшгийн хойно гийгүүлэгч нэмэгдэх

2 янзаар илэрч байна. Тус бүрийг товч дурдая.

Нэг. Бидний дээр дурдсан үе жийрэглэх болон тийн ялгалын нөхцөлийн өмнө тухайн үгийн үндсийн эцсийн гийгүүлэгчийг нэмж хэлдэг нь үүний эхнийхэд хамаарна. Чингэж гийгүүлэгч нэмэгдэхдээ өгүүлэхүйн үйлийг аль болох хялбар дөт байлгах боломжийн үүднээс ихэнхдээ тухайн гийгүүлэгчийг давхарлах буюу уртаар хэлдэг байна. Зарим тохиолдолд зааг гийгүүлэгч нэмэгдэхдээ яг тэр гийгүүлэгч бус, харин аль нэгэн шинжээрээ ойр төстэй өөр гийгүүлэгчийг нэмж хэлдэг. Жишээлбэл, *qumiqu* > *qumbiqu* (хумих-хумбих), *jimiikū* > *jimbiikū* (жимийх-жимбийх), *abayai* ~ *amayai* > *ambayai* (Абагай-Амагай-Амбагай, хүний нэр), *qabar* ~ *qamar* > *qambar* (хамар, ийм бичлэг хуучны бичиг номд мэр сэр тохиолддог), *ūlidte*-(үлид-), *mōddū* (мөд), *nidte* (нит), *ūdter* (үтэр) гэх мэт. Авианзүйн шинжээрээ бүрэн тохирохгүй боловч, ихэнх шинжээрээ ижил, ганц нэг шинжээр ялгарч буй -mb-, -dt- гэх мэт нийлц гарч ирж байгааг давхар гийгүүлэгчийн заримдаг хэлбэр, нэгэн зүйлийн давхар гийгүүлэгч гэж үзэхэд буруудахгүй мэт санагдана. Үүнтэй төстэй үзэгдэл манж хэлэнд бас байна. Жишээ нь: *wasi-bu* > *wasimbu* “буулга”, *wesi-bu* > *wesimbu* “дэвшүүл, айлтга” гэх мэт. Эдгээр үйл үгэн дэх -bu нь үйлдүүлэх хэвийн нөхцөл, “m” нь өмнөх үеийг хааж нэмэгдэж гарч ирсэн зааг гийгүүлэгч юм. Монгол хэлэнд ормол, харь гаралтай үгэнд ч ийнхүү гийгүүлэгч нэмж өгүүлэх ёс байна. Жишээлбэл, *sūmerū* > *sūmber* (Сүмэр > Сүмбэр, санскрит хэлний үг), *omolo* > *ombol/ombolo* (омоло манж хэлний “ач”-ийг заах хүний эшийн нэр, өвөрлөгчдийн хэл аялгуунд омбол хэмээн хэлэлцдэг) г. м.

Монгол бичгийн хэлний олон тооны “*nyūd, nūgūd*” хэлбэрийн үндсэн махбод нь “*ud, ūd*” юм. Эхний “n” нь эгшгийнх нь өмнө нэмэгдсэн зааг гийгүүлэгч бөгөөд нэгэнтээ уртаар дууддаг байсан эгшгийг нь бусад урт эгшигтэй үгийн адилаар дунд нь ү үсэг оруулан бичих болсон байна.

Хоёр. Эгшгийн хойно гийгүүлэгч нэмэгддэг хоёрдох хандлагын жишээнд -ГГЭ (consonant-consonant-vocal), -ГГЭГ, -ГЭ бүтэцтэй залгавар бүтээвэр болон бүтээврийн хувилбарууд холбогдоно.

Монгол хэлний залгавар бүтээврийн хувилбаруудыг эгшиг зохицох ёс, гийгүүлэгч зохицох ёс, эгшиг гийгүүлэгч салаавчлан байрлах авианы байрлалын хуультай холбож санал зөрөлдөөнгүй тайлбарласаар иржээ. Жишээлбэл, үйлдэхийн тийн ялгалын “-аар, -ээр, -өөр, -оор” хувилбарууд нь үгийн эр эм, уруулын ба уруулын бусыг харгалзан эгшиг зохицох ёсоор залгадаг хувилбарууд, үйлийн зэрэгцэхийн “-ж, -ч”, өгөх оршихын “-д, -м” нь гийгүүлэгч зохицох ёс буюу гийгүүлэгчийн чанга сулаар зохицдог хувилбарууд, заахын тийн ялгалын “-г, -ыг/-ийг” нь эгшиг ба гийгүүлэгчийн байртай холбогдсон хувилбар гэдэг нь нэгэнтээ тов тодорхой билээ.

Гэтэл орчин цагийн монгол хэлэнд үйлдэгдэх хэвийн нөхцөл -т, -гд гэсэн хоёр хувилбартай хэмээн хэлзүйн бичгүүд, сурах бичигт зааж бичиж ирэхдээ яагаад хувилбартай болсны учрыг тайлбарлахгүй байна. Нөхцөл төдийгүй дагавар ч ийм

хувилбартай ажээ. Тухайлбал, нэр үгээс үйл үг бүтээх нэгэн дагавар –д, –лд (*da, de /-lda, lde*) хувилбартай. Жишээ нь: хажуу-хажуулдах, нуруу-нуруулдах, хошуу-хошуулдах, ташуу-ташуулдах, өнцөг-өнцөгдөх, дээр-дээрдэх гэх мэт.

–ГГЭ хэлбэрийн бүтээврийн хувилбар төдийгүй, буй бүхий үндсэн хэлбэр нь –ГГЭ бүтэцтэй аливаа дагавар нөхцөлийн учрыг ч анхаарч үзсэнгүй өнөөг хүрчээ. Монгол хэл дэлхийн бусад олон хэлний адил эгшиг гийгүүлэгч харилцан солбицон, бие биеэ салган зааглаж байрлах хуультай. Тэгвэл, хэдий үгийн үндэс язгуур биш боловч, бие даасан бүтээвэр дараалсан хоёр гийгүүлэгчээр эхэлсэн байдаг нь анхаарч судлууштай зүйл гарцаагүй мөн билээ. Ийм бүтэц бүхий бүтээвэр “–*γsan, -gsen, -bci, -ldu/ldū, -bkile, -lkile, -γci/gci* ... гэх мэтээр монгол хэлэнд хэд хэд бий.

Монгол хэлний авианы байрлалын хуулийн үүднээс аваад үзвэл, дараалсан гийгүүлэгчээр эхэлсэн бүтцийг тухайн бүтээврийн анхдагч цөм бүтэц гэж үзэх учиргүй билээ. Бүтээврийн –ГГЭ бүтцийн учрыг тайлбарлахын тулд эхний эгшиг нь балархайшин гээгдсэн, хоёр бүтээвэр нийлсэн, авиа сугарсан, адилсалаар бий болсон зэрэг авианзүйн олон үзэгдэлтэй холбож үзэх боломж бий эсэхийг нягтлан шинжлэх ёстой. Жишээ нь: –втор, втер, втор, втер дагаврын тухайд эгшиг авиа нь балархайшин гээгдсэний улмаас хоёр талын гийгүүлэгч нь нийлсэн бүтэцтэй болжээ.

Миний бодлоор хоёр гийгүүлэгчээр эхэлсэн залгавар бүтээврийн ихэнхэд нь үеийг зааглах гэсэн хандлагын улмаас эгшгийн хойно гийгүүлэгч нэмдэг үзэгдэл түлхүү холбогдоно. Чухам ийм учраас гийгүүлэгчээр төгссөн үйл үндсэнд идэвхгүй хэвийн –д, –т (*-da, -de, -ta, -te*) залгаж, эгшгээр төгссөн үндсэнд –гд (*-γda, -gde*) залгадаг биз ээ.

Ажиглахул, бүтээврийн үндсэн махбодын өмнө их төлөв – *γ/g, -l, -b, -d* гийгүүлэгч нэмэгдэн өмнөх үгийн үндсийн задгай үеийг хааж дэвсгэрлэдэг байна.

Өнөөгийн монголчуудын хэл ярианд зарим гийгүүлэгчийг уртаар дууддаг. /Тухайлбал, Б.Я.Владимирцов *аххā* “ах”, *хаддā* “хад”, *холлō* “хол”, *ellīc* “элс”, *хессёк* “хэсэг”, *хаишī* “хашин”, *ајјī* “аян”, *усс* < *уссū* “ус”, *iddёк* < *iddёдёк* “иддэг”, *боллō* < *боллōлā* “боллоо”, *о́ссā* < *о́ссūсā* “өссөн” зэрэг жишээ авчээ.

Профессор Ж.Санжаа үүнтэй холбогдуулан « *Халх хүний үгийг үелэн хэлж байгааг нарийн ажиглавал e-lёg, ba-jāŋ гээж хэлдэггүй, харин el-lёg, baj-jāŋ гэх мэтээр хэлдгийг төвөггүй мэдэж болно. Ийнхүү богино эгшигийн дараах гийгүүлэгчийг сунжруулан хэлсний учир нь өргөлтөт богино эгшигийг урт эгшигтэй адил сунжруулан хэлэхгүйн тулд, тэргүүн үеийн дараах гийгүүлэгчийг хоёр гийгүүлэгч мэт сунжруулан хэлж, нэг нь тэргүүн үеийн хаалт болж, хоёр дахь нь дараах үеийн эхлэл болдог ажээ. Үүнээс үндэслэн монгол хэлний өргөлтөт богино эгшигтэй задгай үеийг битүү үе болгон хэлэх хандлага бий болж байна гэж үзэж болно. Ийм учраас Э, ГЭ гэх мэтийн богино эгшигтэй үеүд голдуу битүү үе болж хэлэгдэх тул битүү үеийн тоо олишрч, задгай үеийн тоо цөөрч байна* » гэжээ.

Үүнд задгай үеийг битүү үе болгон хэлэх хандлага байна хэмээн бидний таамагтай үндсэндээ санал нийлэх зүйлийг ярианы хэлний баримтаар олж ажигласан байна. Гэхдээ энэ хандлага одоо бий болж байгаа зүйл биш, харин эрт байгаад эдүгээ суларсан

гэж үзэлтэй. Тэр бээр энэ санаагаа лавшруулан «...одоогийн халхын аман дуудлагад дан богино эгшгээс бүтсэн үе байхгүй, гийгүүлэгч эгшгээс бүтсэн задгай үе үгийн тэргүүн үед тохиолдохгүй гэсэн саналтай байгаа юм» гэжээ.

Хуучны бичиг номд “*bayas-un /bayasun/, süsül-ün /süsülün/, ögüler-ün /ögülerün/*” хэмээн төгсгөлийн үеийг нь харьяалахын тийн ялгалын нөхцөлтэй адил салгаж бичсэн газар нэлээд тохиолддог. Магадгүй энэ нь бидний дурдсан үе битүүлэх хандлагатай холбоотой, гагцхүү нэмэгдсэн зааг гийгүүлэгчийг нь бичээгүй хэрэг байж болох юм. Өөрөөр хэлбэл, үгийн үндсийн эцсийн гийгүүлэгч нь дараах нөхцөлийнхөө эгшгээр эхэлсэн үеийн эхэнд орох үеийн зааг бус, харин өмнөх үеэ хааж дэвсгэрлэсэн, үеийнхээ арын зааг гийгүүлэгч нь хэвээр байсан учир тийнхүү салгаж бичдэг байсан бололтой.

Дүгнэлт

1. Монгол бичгийн хэлний жийрэг эгшгийн дүрэмд үе жийрэглэх үзэгдэл байдаг нь зарим судлаачийн үзсэнээр зөв бичих зүйн холбогдолтой төдий бус, эртний монгол хэлний авианы зүй тогтлоос үүдэлтэй гэж үзэв.

2. Үеийг эхэн болон төгсгөлд нь аль болох гийгүүлэгчээр хааж хэлэх гэсэн хандлага эртний монгол хэлэнд байсан нь монгол бичгийн зөв бичих зүйд тусгагдсан байна. Энэ хандлага хойшлох тусам улам бүр алдарсаар иржээ.

3. Монгол хэлэн дэх гийгүүлэгчийг давхарлах буюу уртаар хэлэх үзэгдэл нь тэрхүү хандлагын нэгэн илрэл юм.

4. Монгол хэлний үе битүүлж хэлэх хандлагын үр дүнд дараалсан хоёр гийгүүлэгчээр эхэлсэн /-gda, -gde, -ldu, -ldь, -lča, -lče, -γsan, -gsen ... гэх мэт/ бүтээврийн хувилбарууд бий болжээ.

4. Монгол хэлний давхар гийгүүлэгч фонемийн холбогдолгүй.

5. Өвөг монгол хэлэнд ГЭ, ГЭГ гэсэн үеийн хоёрхон хэв байгаад хойшлох тусам үеийн бүтэц өөрчлөгдсөөр ирсэн байна.

6. Монгол хэлний –ГГЭ бүтэц бүхий нийлмэл ихэнх бүтээврийн эхний гийгүүлэгчийн үүргийг фонеморфологийн үүднээс цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

SUMMARY

There were only two syllable formations ‘CV’ and ‘CVC’ in Proto Mongolian. During the language development, number and structure of syllables of some words have been continuously changed. Phonetic phenomena like consonant dropping, syllable dropping, anaptyxis, consonant and vowel adding have been frequently occurred. Closed consonant before each syllable and after each non-final syllable were existed since the Ancient

Mongolian language, which can be seen from the orthography of the Mongolian script. It connects to the trend that syllable covered as possibly initial and final consonants (CVC). This trend could be shown by two ways.

Firstly, consonant adding before vowel.

It quite commonly occurs to the middle of a word or boundary between two morphemes. In Mongolian orthography, a word ending consonant followed by a suffix beginning with a consonant is inserted vowel. Syllables –du/-dū, -bu/-bū, -gū, -γu will be added after consonants –d, -b, -g, -γ if a suffix beginning with a consonant. For example, *durad-du-mui* “*дурдмүй*”, *jib-bū-mūi* “*жигмүй*”, *ōg-gū-mūi* “*огмүй*”, *kiruγ-γu-mui* “*хярмүй*” etc. These are indices to the orthography of geminate in the Mongolian language. Geminate like –bb-, -gg-, -nn-, -ηη-, -ss-, -rr-, -dd-, -ll-, -yy-, -mm- between the boundary of morphemes occurred frequently in the monuments of Mongolian language written in Mongolian script, ‘Phags-pa script, Horizontal Quadratic script, Soyombo script, Chinese, Arabian, Korean, Manchu and Tibetan. Special geminate derives –dt-, -mb- in a few words.

Secondly, adding consonant after vowel.

Most forms of morphemes of Mongolian are derived from –CCV and –CCVC. Analyzing these, consonants like -γ/g, -l, -b, -d commonly precede the morpheme. For example, suffixes –da, -ta, -de, -te in the passive voice are formed as alternant -γda, -gde when go after vowel.

Double consonant /geminate/ is common in colloquial Mongolian, but this has been disappearing compared to the Ancient Mongolian. However, Mongolian geminate has never connected to the function of phonemes; it is not the static feature in the Mongolian phonetic system.

It is necessary to study the functions of initial consonants of ‘CCV’ and ‘CCVC’ structural affixes of Mongolian by the phonomorphological point of view.